

Living the LOTUS

Buddhism in Everyday Life



VOL. 165

 *Үүсгэн байгуулагчийн сургаал*  

Хүний сайн талыг олж харах нүд

Бүгд л өөрийгөө магтуулахдаа их дуртай байдаг атлаа бусдыг магтахдаа тийм ч дуртай биш юм шиг.

“Явал тань шиг хүний алдаа дутагдлыг хардаггүй, эерэг сайн талыг нь л харж чаддаг болох вэ” гэж хүмүүс их асуудаг юм. Бусдын зөвхөн алдаа дутагдлыг нь л хараад байна гэдэг бол цаад хүнтэйгээ дэндүү их өрсөлдөөд байгаагийн шинж гэж бодогдоно. Сул талаа харуулахгүй юм шүү, ялагдахгүй юм шүү хэмээн өөрийгөө хамгаалахаа л урьтал болгоод байгаа юм биш биз?

Би бол тэгэж хүчээр муйхарлаад байдаггүй. Өөрөөсөө илүү нэгэнд шууд л толгой бөхийн сургаалаа айлдахыг хүсдэг. Бүгд адил Бурханы

хүүхэд учраас өрсөлдөө гээд ямар ч утгагүй. Ийм бодлоор асуудалд хандвал нэгэн хэвэнд баригдсан, өөрийгөө хамгаалсан сэтгэлээсээ ангижирч, аяндаа сэтгэлийн амар амгалан бий болж, нөгөө хүний сайн тал харагдаж ирэх болно. Энэ бол нигүүлслийн мэлмийгээ нээж буй явдал юм.

Жишээлбэл хадам ээж, бэр хоёр энэхүү сэтгэлийн амар амгаланг олж чадвал өдөр бүхэн оронгоороо өөрчлөгдөх болно. Хүнийг сэтгэлээсээ магтаж чадахын нууц үүнд бий гэж бодож байна.

Үүсгэн байгуулагчийн сургаал 9, Х.250-251

Living the Lotus Vol. 165 (2019,06)

Хэвлэсэн: Рисшо Косей Кай, Олон улсын хэлтэс
Хаяг: Fumon Media Center, 2-7-1 Wada, Suginami-ku, Tokyo 166-8537 Japan
TEL: +81-3-5341-1124
FAX: +81-3-5341-1224
Email: living.the.lotus.rk-international@kosei-kai.or.jp
Ахлах редактор: Саитоо Коочироо
Орчуулсан: Ж.Сэлэнгэ
Эхийг хянасан: Монголын РКК

Рисшо Косей кай байгууллага нь Үүсгэн байгуулагч Нивано Никкёо болон түүний шавь Хамтран үндэслэгч Наганүма Мёокоо нарын санаачлагаар 1938 онд байгуулагдсан ба “Гурван Эрдэнийн Цагаан Лянхуа Судар”-ыг гол сургаал номлолоо болгодог, лам бус эгэл хүмүүс нэгдсэн буддын шашны байгууллага юм. Өөрөөр хэлбэл Шагжамүни бурхан багшийн сургаалыг гэр бүл, ажил, нийгмийн амьдралдаа хэрэгжүүлж, дэлхийн энх тайвныг бүтээн байгуульа гэсэн хүсэл зорилготой хүмүүсийн нэгдэл юм. Гишүүд бид бурхан багшийн шавь болохынхоо хувьд тус байгууллагын Ерөнхийлөгч Нивано Ничикоогийн удирдлага дор бурханы сургаалыг түгээх үйлсэд зүтгэж, шашны төдийгүй бусад салбарын байгууллагууд, дэлхийн олон орны хүмүүстэй сэтгэл нэгдэн, энх тайвны олон янзын үйл ажиллагаа явуулж байна.

Living the Lotus – Buddhism in Everyday Life (Амьд Цагаан Лянхуа судар – Буддизм бидний амьдралд)” хэмээх тус сэтгүүлийн нэрэнд, Цагаан лянхуа судрын сургаалыг өдөр тутмынхаа амьдралд хэрэгжүүлж, шаварт ургадаг үзэсгэлэнт лянхуа цэцэг мэт үр бүтээмжтэй, үнэ цэнэтэй амьдралыг тууцгаая гэсэн хүсэл шингэсэн билээ. Бид энэхүү сэтгүүлээр дамжуулан өдөр тутамдаа хэрэгжүүлж болох бурханы сургаалыг дэлхийн өнцөг булан бүрт хүргэж байна.

Бурханы сургаалд суралцах, давтах



Рисшо Косей Кай, Ерөнхийлөгч
Нивано Ничикоо

“Суралцах” гэдэг үйлийг өдөр тутмын амьдралд хэвшүүлэхүй

Сургуульд эрдэм мэдлэг олж авахаар хичээллэхийг “Сурах” гэдэг. Нөгөөтэйгүүр Цагаан Лянхуа Сударын “Уран арга” бүлэгт “Сурах”-тай ижил “Суралцах” гэсэн үг гардаг.

“Олон Бурхадын ном энэ мэт
Түмэн дүнчүүр уран аргасаар
Зүйд нийцүүлэн ном айлдмуй
Түүнд эс суралцагсад бээр
Үүнийг төгсгөж эс чадна”.

Бурхан олон арга хэрэглэж, ямагт хүн бүрт тохирсон сургаалыг айлддаг боловч, “Эс суралцагсад” нь түүнийг анзаарч чаддаггүй гэсэн утгатай.

Эсрэгээр “Суралцах” юм бол хэзээ ч тухайн цаг үед өөрт хэрэг болох Бурханы дохиог анзаарч чадна гэсэн үг.

Сониноос Эгоноки хэмээх мод яг өдийд мөчир дүүрэн цагаан цэцэг дэлбээлүүлдэг ба энэ дүр байдлыг өгүүлсэн мөрт бий. “Мөчирний дуун шаржигнан эгоно цэцэглэнэ” (Кисараги хэлц үгийн толь бичиг “Үнэн амьдрал”/ Франсүдо)

Дэлгэрэн дэлбээлэх цэцэгсийг хараад “Гоё юм аа” гэж бодох хүмүүс олон ч, мөчирний шаржигнах дууг “модны дуу хоолой” гэж мэдрэх мэдрэмж бол шинэлэг юм. Тэгээд тэр “Дуу чимээ” бидэнд юуг өгүүлж байгааг эргэцүүлэн бодвол хэд хэдэн зүйлийг хэлж болно гэж бодож байна.

Алгуурхан цэцэглэх Эгоноки мод зарим хүнд үүсэн бий болж, устан өөрчлөгдөх мөнх бусын учир шалгааныг ухааруулж байхад нөгөө нэгэнд нь “Одоо” энэ амьдралдаа сэтгэл дүүрэн амьдрахын чухлыг “дуу чимээг”-ээр дамжуулж ойлгуулж буй хэрэг болов уу. Энэ нь Бурхан хүн нэг бүрт тухайн цаг үе, тухайн газарт тохирсон сургаалиа айлдаж байдгийн жишээ юм.

Ингэж байгалийн дохионоос эхлээд янз бүрийн үйл явдлаар дамжуулан жинхэнэ үнэнийг мэдэрч, Бурханы дуу хоолойг сонсох гэж хичээснээрээ бид өөрийнхөө төөрөгдөл, шунахай бодлоо эргэцүүлэн анхаарч, амьдрах хүсэл зоригийг олж аван, амьдралдаа нэгэн шинэ алхамыг хийдэг.

Түүнийгээ давтсаар байхыг “Суралцах” гэнэ.





Бодитоор хэрэгжүүлэх нь “Суралцах явдал мөн”

Бидний эргэн тойронд өдөр бүр тохиолдож буй үйл явдлууд бол Бурханы “Хязгааргүй уран арга”-аа бүрэн дүүрэн ашиглан бидэнд айлдаж буй сургаал юм. Хүлээн авах сэтгэл байвал хэн ч байсан гэсэн түүнийг анзаарч чадна.

Гагцхүү “Суралцах” гэдэг нь мэдлэг олж авах гэхээсээ илүү бодитоор дахин давтан хэрэгжүүлсээр “Бурханы сургаалд яг нийцсэн амьдралын хэмнэлийг бие сэтгэлдээ шингээх” явдал юм. Жишээ нь ойр дотны хүнтэйгээ түнжин хагарсан үед цаад хүнийгээ буруутгахаасаа өмнө “Сэтгэл дутсаныг минь харуулж байна уу” хэмээн Бурханы дохиог анзаарч суралцах сэтгэлтэй байвал, цагаан цайлганаар уучилж чадна. Үүний нэгэн адилаар хэдий бэрхшээлтэй нүүр туллаа ч түүнээсээ “Надад юуг сургаж байна вэ” хэмээн суралцаж, өөдрөгөөр хүлээн авч, түүнийгээ хэрэгжүүлэхийг амьдралынхаа хэвшил болгох хэрэгтэй.

Гэвч хүний сэтгэл гэдэг үргэлж, ямар ч зүйлийг Бурханы айлдвар хэмээн хүлээн авахуйц тайван тогтуун байдаггүй. Анзаарсан зүйл тань шууд л сэтгэлд буух үе байхад эргэлзээ тээнэгэлзээ төрүүлж, төөрөгдүүлэх үе ч бий.

Тийм үед төөрөлдсөн зүрх сэтгэлийг дахин Бурханы сургаал уруу чиглүүлдэг зүйл бол “судар уншлага” болон “гишүүн элсүүлэх үйл, тэдори, хооза юм. Тус нийгэмлэгт энэ хоёр дээр “Бурханы сургаалд суралцах” үйлийг нэмээд “сүсэг бишрэлийн гурван үндсэн үйл” гэж нэрлэдэг ба судар уншлага болон хооза ч гэсэн “Бурханы сургаалд суралцах” үйл тул сүсэг бишрэлд тулгуурласан амьдралыг товчхондоо Бурханы сургаалд “Суралцах” явдал гэж хэлж болох биз ээ.

Тэгвэл бид яагаад энэ мэтчилэн “Суралцаж” амьдрах боломжтой вэ гэхээр дээр дурдсан судрын хэсгийн өмнөх мөрөнд“

Гагцхүү нэгэн хөлгөний мөрөөр

Олон бодисадва нарыг номхотгон дагуулж

Ширваган шавь үгүй” хэмээн айлдсан нь бидэнд Бодисадвагийн сэтгэл байгааг илэрхийлж байгаа юм. Өөрөөр хэлбэл зөвхөн өөрөө л аз жаргалтай болвол болоо гэж боддог хүн үгүй гэсэн үг. Тэр утгаараа бид бусдын аз жаргалын төлөө залбиран сургаалыг дамжуулах нь ч маш чухал “Суралцах” үйл болох бөгөөд өрөөл бусадтай нэгэн бүхэл сэтгэлтэй болохын их баяр баясгалан, аз жаргал тэнд бий билээ.

«Косей» сэтгүүлийн 2019 оны 6 сарын дугаараас



Лянхуан Гурамсан Сударын бүлэг тус бүрийн тайлбар

Оройн Дээд Цагаан Лянхуа Судар 500 шавь нарын эш авсныг өгүүлэх 8 дугаар бүлэг

Энэ бүлэгт Пүрнагаас эхлээд олон өндөр дээд шавь нарт “Зайлшгүй Бурханы түвшинд хүрэх буй за” хэмээх батламж олгогддог.

Шагжамүни будда Пүрна бол Номоор Гийгүүлэгч Түүнчлэн Ирсэн хэмээх нэртэй Бурхан болох бөгөөд бусад нь бүгд Хотлоор Гийгүүлэгч Түүнчлэн Ирсэн хэмээх нэртэй Бурхад болох буй за хэмээн батлаад мөн “Бусад олон ширваганууд ч басхүү энэ мэт болмуй” гэж айлддаг. Өөрөөр хэлбэл Бурханы сургаалыг сонсоод гэгээрэлд хүрье гэсэн хувирашгүй сэтгэлээр хичээн зүтгэгч нь хэзээ нэгэн цагт гарцаагүй гэгээрэлд хүрч, Хотлоор Гийгүүлэгч Түүнчлэн Ирсэн гэдэг Бурхан болно хэмээн баталсан байдаг.

Түүнчлэн Махакаашяпад “Тэрчлэн энэ чуулганаа үл суугчдад ч чи бээр магад сонордуулбаас зохимуй. (Үүнийг дамжуулагтун)” хэмээн зарлиг болдог. Энэ нь шууд утгаараа өмнөх “Уран аргас”-ын бүлэгт Бурханыг ном айлдаж байх үеэр суудлаасаа босон гарч явсан “Таван мянган хүмүүс” –ийг хэлж байгаа гэдэг. Өөрөөр хэлбэл “Нэг удаа Бурханы сургаалыг сонсох ерөөлтэй хүн нь түрхэн зуур харьж шантарч болох боловч тэрхүү ерөөлийн үр дүн нь заавал соёолж, хэзээ нэгэн цагт Бурханы мөрд эргэн ирээд, Бурханы гэгээрлийг олох буй за” гэсэн утгатай.

Мөн энэ нь хожмын үеийн Бурханы шавь болсон бид ч гэсэн Цагаан Лянхуа Сударын сургаал номлолоос суралцаж, хэрэгжүүлж явбал гарцаагүй Хотлоор Гийгүүлэгч Түүнчлэн ирсэн болж чадна гэсэн утгатай.

Хүн бүхэн Хотлоор Гийгүүлэгч Түүнчлэн Ирсэн болох тухай

Хотол гэдэг нь түгэн дэлгэрэх гэсэн үгнээс гаралтай тул Хотлоор Гийгүүлэгч Түүнчлэн Ирсэн гэдэг нь хорвоо ертөнцөд гэрэл гэгээг түгээн дэлгэрүүлэгч Түүнчлэн Ирсэн гэсэн утгатай. Энэ бүлэгт гарч байгаа Бурхан

багшийн айлдварт “Дэс дарааллан Бурхан болохыг эш үзүүлье” гэх үг бий бөгөөд тэр нь нэгээс нөгөөдөө дамжин ар араасаа эш үзүүлэн явах гэсэн утгатай. Тиймээс Бурханы сургаалаар амьдрагч бид бүхэн хэзээ нэгэн цагт хэн нэгнээс Бурхан болох баталгаа авах учиртай ба мөн хэн нэгнийг батлах үүрэгтэй. Энэ мэтчилэн үеэс үед Хотлоор Гийгүүлэгч Түүнчлэн Ирсэн Бурхан нэмэгдсээр байвал хорвоо ертөнц гэрэл цацарсан амар амгалан ертөнц болж хувирах учиртай.

Тийм гайхамшигтай баталгаа энэхүү бүлгийн

хамгийн чухал хэсэг нь гэж ойлгож болно. Ингэж итгэхгүй байхын аргагүй.



Хувцсан доторх үнэт чулууны зүйрлэл

Ингээд Шагжамүни Бурханаас шууд Бурхан болох баталгааг авсан шавь нар баяр хөөр болцгоож, талархалаа илэрхийлэхийн сацуу Каундиня хэмээгч шавь нь бүгдийг төлөөлөн “өнөөг хүртэл олж авсан ердийн мэдлэгтээ сэтгэл ханасан байсан алдаагаа дараах эшлэлээр илчилдэг.

“Нэгэн ядуу хүн бээр дотны найзаасаа туслахыг хүсэн гуйж ирдэг. Найз нь архи болон загас гарган арвин ихээр дайлж цайлсан тул нөгөө хүн их согтож, нэг мэдэхэд унтчихжээ.

Гэтэл найз нь гэнэтийн зайлшгүй хэргээр гарч явахаас өөр аргагүй болов. Унтаж байгаа найзыгаа сэрээгээд яахав хэмээн бодоод, түүнд хэмжээлж баршгүй их үнэ цэнэтэй үнэт чулууг хувцасных нь дотор талд оёж өгөөд явжээ.

Нойрноосоо сэрээд нөгөө хүн найзыгаа гэнэтийн хэргээр гараад явчихсаныг мэдээд аргагүйн эрхэнд тэндээс явсан ч өнөөх л ядуу хэвээр амьдарч, эцэстээ тэнүүлчний амьдралд оржээ. Тэгээд хоол унд, хувцас хунарын төлөө хүнд хүчир бүхнийг хийн зовж, өчүүхэн төдий орлого олдвол түүндээ сэтгэл нь ханах байдалтай байж.

Багагүй хугацаа өнгөрсөн хойно тэрээр нөгөөх эртний найзтайгаа зам дээр тааралдаж гэнэ. Найз нь түүний огтхон ч өөрчлөгдөөгүй өрөвдөм байдлыг хараад “Чи чинь яасан мунхаг хүн бэ. Би чамайг амар сайхан амьдраг гээд хувцас дотор чинь үнэтэй эрдэнийн чулууг оёж үлдээсэн байхад” гэжээ.

Тэгээд алмайран зогссон найзынхаа ноорхой хувцаснаас тэрхүү үнэт эрдэнийн чулууг гаргаад “За үүнийг зараад юу хэрэгтэй бүхнээ ав. Дутагдаж гачигдах зүйлгүй амьдар” гэжээ.

Дээрх зүйрлэлийг хэлээд Каундиня “Бурхан багш бол энэ найз шиг нь хүн юм. Бурхан багш хараахан Будда болон гэгээрээгүй бодисадва байхдаа бидэнд “Хэнд ч Бурханлаг чанар (Үнэлж баршгүй их үнэ цэнэтэй эрдэнийн чулуу) бүрдсэн байдаг тул бясалгаж Бурханы гэгээрлийг олоосой...” хэмээн сургасан байдаг боловч бидний зүрх сэтгэлийн унтаа байдал нь түүний жинхэнэ утгыг ухаарч чадаагүй. Тэгээд зүгээр л хүндрэл бэрхшээлийг зайлуулж чадсан төдийгөөр түүнийгээ гэгээрэл хэмээн бат бодож байжээ. Гэвч бид сэтгэлийнхээ гүнд жинхэнэ



Бурханы гэгээрлийг хүсэж байсан. Нэг л учир дутагдалтай санагдаад байсан юм. Сая л Ялж Төгс Нөгчсөн Бурхан бээр миний нүдийг тов тодорхой нээж өглөө. Би одоо л бодисадва боллоо. Цаашид бодисадвагийн замналаар замнаж, ертөнцийн хүмүүний төлөө зүтгэж явбал аяндаа л Бурхан болж чадахыг ойлголоо. Ийм талархууштай зүйл хаа ч үгүй.” хэмээн сэтгэл зүрхнээсээ талархсанаар энэ бүлэг дуусна.

Хүн өөрийн мөн чанарыг мэддэггүй

Бурханлаг чанарт “Бурхан болж чадах чадвар” ба “Тэр чигээрээ Бурхан” гэсэн утга байдаг. Эхнийх нь ямар ч хүн байсан хичээж зүтгэсээр хэзээ нэгэн цагт заавал Бурхан болж чадах, тэгсэнээр Бурханлаг чанар гэсэн зүйлийг дадлага сургууль гэсэн талаас нь авч үзсэн утгатай. Дараагийнх нь бүх хүний жинхэнэ мөн чанар нь Бурханлаг чанар тэр чигээрээ гэж үзэх бөгөөд Бурханлаг чанар гэдэг зүйлийг тэрхүү мөн чанараас нь авч үзсэн утгатай.

Бид бүгдээрээ ийм утга бүхий Бурханлаг чанартай ч түүнийгээ огт мэдэрч чаддаггүй. Учир нь “Хувцас хунар, хоол ундханы төлөө зав чөлөөгүй ажиллаж амьдран, хүсэл шуналдаа хүлэгдсэн энэ бие, сэтгэл л бидний мөн чанар юм” гэсэн бодолдоо бүр автчихсан байдаг. Дээрх эшлэлд гарсан ядуу хүн бол бидний тийм дүр төрхийг илэрхийлж буй юм.

Баян найз нь буюу өнө мөнхийн Бурхан нь ямар ч эгэл хүнд Бурханы хутаг хэмээх үнэт эрдэнэсийг өгсөн байтал эгэл хүмүүн бид хүсэл шуналдаа автсанаас болж түүнийг огт анзаарч чаддаггүй. Тиймээс огт аврагдаж чадалгүй, чөлөө зайгүй зовлонт амьдралаар амьдардаг.

Шагжамүни Бурханы сургаалын ачаар анх удаа анзаарна

Энэ ертөнцөд гарч ирсэн Будда болох Шагжамүни Бурхан “Бүх хүнд ижил тэгш Бурханлаг чанар бий. (Хувцсан доторх үнэт чулуу)” гэж заахад нь анх удаа бид анзаарсан. Түүнийг анзаарсан тэр агшинд сэтгэл зүрх уужирч, ирээдүйгээ өөдрөгөөр харж, эрх чөлөөг мэдэрч, цаашдын амьдралдаа итгэх бат итгэлийг олж авдаг.

Хэдийнээ бурханы авралд багтсан байдаг

Өөрөөр хэлбэл энэ эшлэлд “Бид үнэндээ авралд багтсан байдаг. Бидний жинхэнэ мөн чанар бол өнө мөнхийн жинхэнэ Бурхантай нэгэн адил бөгөөд эрх чөлөөтэй Бурханлаг чанар юм. Бид Тэрхүү үнэнийг мэдэхгүйгээсээ болж зовлонт амьдралаар төөрч будилдаг. Угтаа бурханы авралд багтах хэцүү зүйл биш юм. Өөрийн тань мөн чанар Бурханлаг чанар бөгөөд анхнаасаа л бурханы авралд багтсан байдгийг биеэрээ мэдрэхэд л болно.” хэмээн энэхүү бүлэгт айлдсан байна.



Дахин дахин суралцаж, хэрэгжүүлэх нь

Энэ сард Нивано ерөнхийлөгч сургаалдаа “дахин суралцах” талаар айлджээ.

Нивано ерөнхийлөгч өнөөдрийг хүртэл Бурханы сургаалаас дахин дахин суралцах нь ямар чухал болох талаар олонтоо айлдсаар ирсэн. Бүх үзэгдэл, нөхцөл байдал нь бурханы түмэн уран аргын илэрхийлэл болон айлдагдаж буй сургаал учраас байгалийн зохилдлого болон төрөл бүрийн үйл явдлын дотроос жинхэнэ үнэнийг олж харан, мэдэрч бурханы хоолойг сонсохын чухлыг заалгалаа.


Өдөр тутмын амьдралдаа дахин дахин суралцахын хажуугаар, хэрэгжүүлэх нь чухал гэж маш ойлгомжтой айлджээ. Энэ дагуу хэрэгжүүлэхийн тулд “судар уншлага”, “гишүүн элсүүлэх, тэдори, хооза”, “сургаалаас дахин дахин суралцах” гэсэн үндсэн үйлүүдийг хичээнгүйлэн хийх хэрэгтэй. Ялангуяа ганцхан өөрийн авралын төлөө биш бусадтай хамтдаа аз жаргалтай болох жинхэнэ авралын төлөө хэмээх бодисадвагийн үйл, сургаал түгээх үйл, гишүүн элсүүлэх үйлүүдийг хичээнгүйлэн үйлдэхийг хүсэж байна.

РКК, Олон улсын хэлтсийн дарга
Саитоо Коичи



✉ We welcome comments on our newsletter Living the Lotus: living.the.lotus.rk-international@kosei-kai.or.jp

Rissho Kosei-kai: A Global Buddhist Movement



Rissho Kosei-kai International

Fumon Media Center 3F, 2-7-1 Wada, Suginami-ku, Tokyo, Japan
 Tel: 81-3-5341-1124 Fax: 81-3-5341-1224
 e-mail: living.the.lotus.rk-international@kosei-kai.or.jp

Rissho Kosei-kai International of North America (RKINA)

2707 East First Street, Suite #1, Los Angeles, CA 90033, U.S.A.
 Tel: 1-323-262-4430 Fax: 1-323-262-4437
 e-mail: info@rkina.org <http://www.rkina.org>

Branch under RKINA

Rissho Kosei-kai of Seattle's Buddhist Learning Center

28621 Pacific Highway South, Federal Way, WA 98003 U.S.A.
 Tel: 1-253-945-0024 Fax: 1-253-945-0261
 e-mail: rkseattlewashington@gmail.com
<http://buddhistlearningcenter.org/>

Rissho Kosei-kai Buddhist Center of San Antonio

6083 Babcock Road, San Antonio, TX 78240, U.S.A.
 P.O. Box 692148, San Antonio, TX 78269, U.S.A.
 Tel: 1-210-561-7991 Fax: 1-210-696-7745
 e-mail: dharmasanantonio@gmail.com
<http://www.rkina.org/sanantonio.html>

Rissho Kosei-kai of Tampa Bay

2470 Nursery Road, Clearwater, FL 33764, U.S.A.
 Tel: (727) 560-2927 e-mail: rktampabay@yahoo.com
<http://www.buddhismtampabay.org/>

Rissho Kosei-kai of Vancouver

Rissho Kosei-kai Buddhist Church of Hawaii

2280 Auhuhu Street, Pearl City, HI 96782, U.S.A.
 Tel: 1-808-455-3212 Fax: 1-808-455-4633
 e-mail: info@rkhawaii.org <http://www.rkhawaii.org>

Rissho Kosei-kai Maui Dharma Center

1817 Nani Street, Wailuku, HI 96793, U.S.A.
 Tel: 1-808-242-6175 Fax: 1-808-244-4625

Rissho Kosei-kai Kona Dharma Center

73-4592 Mamalahoa Highway, Kailua-Kona, HI 96740 U.S.A.
 Tel: 1-808-325-0015 Fax: 1-808-333-5537

Rissho Kosei-kai Buddhist Center of Los Angeles

2707 East First Street, Los Angeles, CA 90033, U.S.A.
 Tel: 1-323-269-4741 Fax: 1-323-269-4567
 e-mail: rk-la@sbcglobal.net <http://www.rkina.org/losangeles.html>

Rissho Kosei-kai Buddhist Center of Arizona

Rissho Kosei-kai Buddhist Center of Colorado
 Rissho Kosei-kai Buddhist Center of San Diego
 Rissho Kosei-kai Buddhist Center of Las Vegas
 Rissho Kosei-kai Buddhist Center of Dallas

Rissho Kosei-kai of San Francisco

1031 Valencia Way, Pacifica, CA 94044, U.S.A.
 Tel: 1-650-359-6951 Fax: 1-650-359-6437
 e-mail: info@rksf.org <http://www.rksf.org>

Rissho Kosei-kai of Sacramento

Rissho Kosei-kai of San Jose

Rissho Kosei-kai of New York

320 East 39th Street, New York, NY 10016 U.S.A.
 Tel: 1-212-867-5677 Fax: 1-212-697-6499
 e-mail: rkny39@gmail.com <http://rk-ny.org/>

Rissho Kosei-kai of Chicago

1 West Euclid Ave., Mt. Prospect, IL 60056 U.S.A.
 Tel: 1-773-842-5654 e-mail: murakami4838@aol.com
<http://rkchi.org/>

Rissho Kosei-kai of Fort Myers

<http://www.rkftmyersbuddhism.org/>

Rissho Kosei-kai Dharma Center of Oklahoma

2745 N.W. 40th Street, Oklahoma City, OK 73112 U.S.A.
 Tel: 1-405-943-5030 Fax: 1-405-943-5303
 e-mail: rkokdc@gmail.com <http://www.rkok-dharmacenter.org>

Rissho Kosei-kai Dharma Center of Denver

1255 Galapago Street, #809 Denver, CO 80204 U.S.A.
 Tel: 1-303-446-0792

Rissho Kosei-kai Dharma Center of Dayton

425 Patterson Road, Dayton, OH 45419 U.S.A.
<http://www.rkina-dayton.com/>

Rissho Kosei-kai do Brasil

Rua Dr. José Estefno 40, Vila Mariana, São Paulo-SP,
 CEP 04116-060 Brasil
 Tel: 55-11-5549-4446 / 55-11-5573-8377 Fax: 55-11-5549-4304
 e-mail: rissho@terra.com.br <http://www.rkk.org.br>

Rissho Kosei-kai de Mogi das Cruzes

Av. Ipiranga 1575-Ap 1, Mogi das Cruzes-SP,
 CEP 08730-000 Brasil
 Tel: 55-11-5549-4446 / 55-11-5573-8377

Rissho Kosei-kai of Taipei

4F, No. 10 Hengyang Road, Zhongjheng District,
Taipei City 100, Taiwan

Tel: 886-2-2381-1632 Fax: 886-2-2331-3433
<http://kosei-kai.blogspot.com/>

Rissho Kosei-kai of Tainan

No. 45, Chongming 23rd Street, East District,
Tainan City 701, Taiwan

Tel: 886-6-289-1478 Fax: 886-6-289-1488

Korean Rissho Kosei-kai

6-3, 8 gil Hannamdaero Yongsan gu, Seoul, 04420,
Republic of Korea

Tel: 82-2-796-5571 Fax: 82-2-796-1696
e-mail: krkk1125@hotmail.com

Korean Rissho Kosei-kai of Busan

3F, 174 Suyoung ro, Nam gu, Busan, 48460, Republic of Korea
Tel: 82-51-643-5571 Fax: 82-51-643-5572

International Buddhist Congregation (IBC)

Fumon Media Center 3F, 2-7-1 Wada, Suginami-ku, Tokyo, Japan

Tel: 81-3-5341-1230 Fax: 81-3-5341-1224

e-mail: ibcrk@kosei-kai.or.jp <http://www.ibrk-rk.org/>

Branches under the Headquarters**Rissho Kosei-kai of Hong Kong**

Flat D, 5/F, Kiu Hing Mansion, 14 King's Road,
North Point, Hong Kong, Republic of China

Rissho Kosei-kai of Ulaanbaatar

15F Express tower, Peace avenue, khoroo-1, Chingeltei district,
Ulaanbaatar 15160, Mongolia

Tel: 976-70006960 *e-mail:* rkkmongolia@yahoo.co.jp

Rissho Kosei-kai of Sakhalin

4 Gruzinski Alley, Yuzhno-Sakhalinsk
693005, Russian Federation

Tel & Fax: 7-4242-77-05-14

Rissho Kosei-kai Friends in Shanghai**Rissho Kosei-kai of South Asia Division**

201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkapi, Huaykhwang
Bangkok 10310, Thailand

Tel: 66-2-716-8141 Fax: 66-2-716-8218

Rissho Kosei-kai International of South Asia (RKISA)

201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkapi, Huaykhwang
Bangkok 10310, Thailand

Tel: 66-2-716-8141 Fax: 66-2-716-8218

e-mail: thairissho@csloxinfo.com

Branches under the South Asia Division**Rissho Kosei-kai of Delhi**

77 Basement D.D.A. Site No. 1, New Rajinder Nagar,
New Delhi 110060, India

Rissho Kosei-kai of Kolkata

E-243 B. P. Township, P. O. Panchasayar, Kolkata 700094,
West Bengal, India

Rissho Kosei-kai of Kolkata North

AE/D/12 Arjunpur East, Teghoria, Kolkata 700059,
West Bengal, India

Rissho Kosei-kai of Bodhgaya

Ambedkar Nagar, West Police Line Road
Rumpur, Gaya-823001, Bihar, India

Rissho Kosei-kai of Kathmandu

Ward No. 3, Jhamsilhel, Sancepa-1, Lalitpur, Kathmandu,
Nepal

Rissho Kosei-kai of Phnom Penh

#201E2, St 128, Sangkat Mittapheap, Khan 7 Makara,
Phnom Penh, Cambodia

Rissho Kosei-kai of Patna**Rissho Kosei-kai of Singapore****Thai Rissho Friendship Foundation**

201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkapi, Huaykhwang
Bangkok 10310, Thailand

Tel: 66-2-716-8141 Fax: 66-2-716-8218

e-mail: info.thairissho@gmail.com

Rissho Kosei-kai of Bangladesh

85/A Chanmari Road, Lalkhan Bazar, Chittagong, Bangladesh

Tel & Fax: 880-31-626575

Rissho Kosei-kai of Dhaka

House#408/8, Road#7(West), D.O.H.S Baridhara,
Dhaka Cant.-1206, Bangladesh

Tel & Fax: 880-2-8413855

Rissho Kosei-kai of Mayani

Mayani(Barua Para), Post Office: Abutorab, Police Station:
Mirshari, District: Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Patiya

Patiya, sadar, Patiya, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Domdama

Domdama, Mirsarai, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Cox's Bazar

Ume Burmese Market, Main Road Teck Para, Cox'sbazar,
Bangladesh

Rissho Kosei-kai of Satbaria

Satbaria, Hajirpara, Chandanish, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Laksham

Dupchar (West Para), Bhora Jatgat pur, Laksham, Comilla,
Bangladesh

Rissho Kosei-kai of Raozan

West Raozan, Ramjan Ali Hat, Raozan, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Chendirpuni

Chendirpuni, Adhunagor, Lohagara, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Ramu**Rissho Kosei Dhamma Foundation, Sri Lanka**

No. 628-A, Station Road, Hunupitiya, Wattala, Sri Lanka

Tel: 94-11-2982406 Fax: 94-11-2982405

Rissho Kosei-kai of Habarana

151, Damulla Road, Habarana, Sri Lanka

Rissho Kosei-kai of Polonnaruwa**Branches under the Headquarters****Rissho Kosei-kai di Roma**

Via Torino, 29-00184 Roma, Italia

Tel & Fax: 39-06-48913949 *e-mail:* roma@rk-euro.org

Rissho Kosei-kai of the UK**Rissho Kosei-kai of Venezia****Rissho Kosei-kai of Paris**